



Товч зөвлөмж

- Нийслэл, бүсийн түвшний хадгалалт, борлуулалт, түгээлтийн төвүүд байгуулах замаар төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, ложистикийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх нь зүйтэй.
- Улаанбаатар хотын дэргэд байгуулах цогцолбор төв нь жилд 75 мянган тонн төмс, хүнсний ногоо борлуулах хүчин чадалтай, 20 мянган тоннын механикжсан агуулахын багтаамжтай, дэргэдээ хүнсний аюулгүй байдлын лаборатори, сав баглаа боодлын болон хүнсний ногоо боловсруулах цехтэй байна.
- Улаанбаатар хотын дэргэд цогцолбор төвийг байгуулахад 3.5 га газар, 100 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдана.
- Санал болгосон цогцолбор төв нь нийгмийн бизнесийн шинж чанартай тул хөрөнгө оруулалтад төр оролцох нь зүйтэй.
- Цогцолбор төвийн статусын хувьд а) төр, хариуцагч ААН, ногоочдын хоршоодын хамтарсан хувьцаат компани, б) төрөөс гарааны хөрөнгө оруулалтын зохих хувийг эргэн төлөгдөх нөхцлөөр хариуцаж, хариуцагч компани болон ногоочдын хоршоодын хамтын өмчлөлийн хэлбэрээр байгуулах гэсэн хувилбаруудыг санал болгож байна.

Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн цогцолбор төв байгуулах үндэслэл, шийдэл

Хүн амын өсөлт, уур амьсгалын өөрчлөлт эрчимжиж буй өнөө цаг үед хүнс үйлдвэрлэлийг тогтвортой нэмэгдүүлэх чиглэлээр дэлхийн бүх улс орнууд, тэр дундаа Монгол улс “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд бодлого, чиглэлээ тодорхойлон ажиллаж байна. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх нэг чиглэл нь хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээ, нэр төрлийг нэмэгдүүлж, импортоос хараат байдлыг бууруулах явдал юм. Үйлдвэрлэл үр ашигтай байж өргөжин тэлэх бодит бололцоо бүрдэнэ. Гэтэл хүнсний ногооны салбарт хадгалалт, борлуулалтын тогтолцоо төлөвшөөгүйгээс шалтгаалж завсрын шат дамжлага ихтэй, үйлдвэрлэгчийн ба хэрэглэгчийн үнийн хооронд ихээхэн зөрүүтэй, борлуулалтын ашгийн ихэнх хувийг борлуулагчид хүртэж буй нь үйлдвэрлэлийн үр ашиг болон хүнсний ногооны хэрэглээг хязгаарлаж байна. Цаашид төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ асуудал салбарын бодлогод ч тусгагдсан байдаг. Нэгдсэн тогтолцооны үндсэн бүрдэл хэсгүүд болох хадгалалт, борлуулалт, түгээлтийн цогцолбор төвүүд Монгол оронд урьд өмнө баригдаж байгаагүй тул олон улсын түршлагыг судалж, өөрийн орны онцлогт нийцсэн загвар, шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нь зүйтэй. Бид Улаанбаатар хотын дэргэд байгуулж болох цогцолбор төвийн урьдчилсан бүтэц, загварыг энэхүү бодлогын зөвлөмжинд танилцуулахын хамт уг санаачлагыг бодитоор хэрэгжүүлэх, энэ чиглэлээр бодлого боловсруулахад зориулан бэлтгэсэн санал, зөвлөмжийг толилуулж байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл, импорт, зах зээл

Манай улс 2021 онд 182.7 мянган тонн төмс үйлдвэрлэж, 100.9 тонн таваарын төмс, 99.8 тонн үрийн төмс импортолсон. Харин хүнсний ногоо 197.2 мянган тонн нийлүүлэгдсэний 61.7 хувийг дотоодод үйлдвэрлэсэн бөгөөд 2021 онд 76.0 мянган тонн хүнсний ногоо

Implemented by





импортолж, үүнд 19.3 сая ам.доллар зарцуулжээ. Сүүлийн 10 жилийн дунджаар хүнсний ногооны нийлүүлэлт 174 мянган тонн, түүний 57 хувийг дотоодоос хангаж байна (1-р зураг).



Зураг 1: Хүнсний ногооны нийт нийлүүлэлт, түүний бүтэц 2012-2021 онд

Эх сурвалж: YCX, 2016; YCX, 2022a.

Төмсний зах зээлийг 2021 онд зах зээлд дотоодоос нийлүүлсэн 182.6 мянган тонн төмс, импортоор нийлүүлсэн 200.7 тонн төмсний нийлбэр үнээр тооцвол төмсний зах зээлийн нийт үнэлгээ 110.2 тэрбум төгрөг. Хүнсний ногооны нийлүүлэлтийн мөнгөн дүн болох 292.7 тэрбум төгрөгийг нэмбэл боловсруулаагүй төмс, хүнсний ногооны зах зээлийн нийт үнэлгээ 402.9 тэрбум төгрөг, үүний 86 хувийг дотоодын нийлүүлэлт эзэлж байна (1-р хүснэгт).

Хүснэгт 1: Боловсруулаагүй төмс, хүнсний ногооны зах зээлийн мөнгөн үнэлгээ, 2021 оны байдлаар

Ангилал	Хэмжээ, 1000 т	Нийт үнэ, тэрбум төгрөг
Дотоодын нийлүүлэлт		
Төмс	182.6	109.6
Хүнсний ногоо	121.5	232.0
Дотоодын нийлүүлэлтийн дүн	304.1	341.5
Импорт		
Төмс	0.2	0.6
Хүнсний ногоо (боловсруулаагүй)	76.0	55.1
Импортын дүн	76.2	55.7
Нийт зах зээлийн үнэлгээ		397.3

Жишсэн хүн амын хэрэгцээ, хангамж

Монгол Улсын жилийн эцсийн суурин хүн амын тоо 2021 онд 3312.3 мянга, жишсэн хүн амын тоо 2682.6 мянга болсон бөгөөд хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүнээс төмс, хүнсний ногоог авч үзвэл зохистой хэрэгцээ нь 117.5 мянган тонн төмс, 254.6 мянган тонн хүнсний ногоо байв. Зөвхөн Улаанбаатар хотын жишсэн хүн амыг жишсэн хүнд шилжүүлэн тооцвол жилд 54.8 мянган тонн төмс, 118.6 мянган тонн хүнсний ногоо жилд хэрэглэх бодит хэрэгцээ бий (2-р хүснэгт).

МХШФХ-ны 2016 онд гүйцэтгэсэн “Төмс, хүнсний ногооны өртгийн сүлжээний судалгаа”-нд ашиглагдсан жишиг нормуудыг ашиглан хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээний хорогдол ногдуулан тооцож үзвэл 2021 онд 155.2 тонн төмс, 161.5 тонн хүнсний ногоо хэрэглэжээ (3-р хүснэгт).



Энэхүү тооцооноос үзэхэд хүнсний ногооны хангамж 63 хувь, үүний 38 хувийг дотоодоос, 25 хувийг импортоор нийлүүлж байна. Хүнсний ногооны дутагдал 37 хувь буюу өөрөөр хэлбэл хэрэгцээг бүрэн хангахад 93 мянган тонн хүнсний ногоо дутагдаж байна.

Хүснэгт 2: Жишсэн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээ, 2021 онд

Хамрах цар хүрээ	Жишсэн хүн ам, 1000 хүн	Жишсэн хүний жилийн хэрэгцээ, кг		Нийт хэрэгцээ, 1000 тн	
		Төмс	Хүнсний ногоо	Төмс	Хүнсний ногоо
Монгол улс	2682.6	43.8	94.9	117.5	254.6
Улаанбаатар хот	1250.0	43.8	94.9	54.8	118.6

Хүснэгт 3: Төмс, хүнсний ногооны баримжаалсан бодит хангамж, 2021 онд

Ангилал	Нийт нийлүүлэлт, 1000 тонн	Хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, хэрэглээний хорогдол		Бодит хангамж, 1000 тн
		Хувь	1000 тонн	
Төмс, дотоодын	182.6	15	27.4	155.2
Хүнсний ногоо, дотоодын	121.5	20	24.3	97.2
Хүнсний ногоо, импорт	75.7	15	11.4	64.3
Хүнсний ногоо, нийт	197.2			161.5

Эх сурвалж: ҮСХ, 2022а; ҮСХ, 2022б.

Өртгийн сүлжээ

Төмс, хүнсний ногооны өртгийн сүлжээний талаар 2020 онд Азийн Хөгжлийн Банкнаас гүйцэтгэсэн судалгаанаас хүнсний ногооны нийт 5 гол өртгийн сүлжээг тодорхойлж, нийт худалдаанд эзлэх хувь хэмжээгээр нь эрэмбэлсэн байдлыг 4-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4: Хүнсний ногооны худалдаанд гол өртгийн сүлжээнүүдийн эзлэх хувь

Гол Өртгийн Сүлжээ		Нийт тооцоолсон эрэлтэд эзлэх хувь (%)
Өртгийн сүлжээ 1	Жижиг тариалан эрхлэгч эсвэл хувиараа ногоо таригчид – ченжүүд эсвэл том нийлүүлэгч – Бөөний худалдаачин – зах эсвэл худалдааны төвүүд (жижиглэн худалдаачид) – эцсийн хэрэглэгчид	50
Өртгийн сүлжээ 2	Том эсвэл Дунд хэмжээний Тариаланчид – Нэрийн дэлгүүр, худалдааны төвүүд эсвэл бусад борлуулалтын цэгүүд – эцсийн хэрэглэгчид	10
Өртгийн сүлжээ 3	Импортлогч – ченжүүд эсвэл том нийлүүлэгчид – Бөөний худалдаачид – Захууд эсвэл Худалдааны төвүүд (жижиглэн худалдаачид) – эцсийн хэрэглэгч	25
Өртгийн сүлжээ 4	Жижиг тариалан эрхлэгч болон хувиараа ногоо таригчид эсвэл импортлогч – Боловсруулах үйлдвэрүүд – Захууд эсвэл Худалдааны төвүүд (жижиглэн худалдаачид) – хэрэглэгч	10
Өртгийн сүлжээ 5	Жижиг тариалан эрхлэгч эсвэл хувиараа ногоо таригчид, том болон дунд хэмжээний тариаланчид – том борлуулагч “С” – хэрэглэгч (шууд худалдан авалтын загвар)	5

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк, 2020

Хүснэгтээс үзэхэд тариаланчаас ченжид, ченжээс бөөний худалдааны төвүүд хүнсний зах, худалдааны төвүүдээр дамжин эцсийн хэрэглэгчдэд хүрэх хувилбар давамгайлж буй бөгөөд энэ шат дамжлагуудыг дамжсан хүнсний ногооны үнэ хэрэглэгч хүртлээ дунджаар 61-132 хувь хүртэл нэмэгддэг байна. Тухайлбал ченжүүд хүнсний ногоог байгууллагын худалдан авалтад зуучилдаг



компаниудад худалдахдаа тариаланчаас авсан үнэ дээр 61 хувь, бөөний худалдаачдад өгөхдөө 82 хувь нэмдэг бол ченжүүдээс жижиглэн худалдаачдаар дамжин борлогдоход эдгээр оролцогчдын авах ашиг нэмэгдэж, үйлдвэрлэгчийн үнэ, хэрэглэгчийн үнийн зөрүү хүнсний захуудад 147 хувь, худалдааны төвүүдэд 162 хувь хүрдэг болохыг тогтоожээ. Бусад өртгийн сүлжээнүүдийг авч үзвэл уг үнийн зөрүү 2-с 4-р өртгийн сүлжээнүүд 85-1446 хувь, харин ченжээр дамжилгүй шууд томоохон худалдааны төв, борлуулагчдаар дамжин хэрэглэгчдэд хүрэх харьцангуй шинэ өртгийн сүлжээнд худалдааны төв нь ногоочдоос авсан үнэ дээр дунджаар 22 хувь нэмж хэрэглэгчдэд хүрч байна.

Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн цогцолбор төв байгуулах бодлогын үндэслэл

Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн цогцолбор төвүүдийг Улаанбаатар хот болон бүсийн тулгуур төвүүдэд байгуулах асуудал нь бодлогын дараах зорилтуудад нийцнэ:


- “Алсын Хараа - 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны (2021-2030 он) 8.3-р зорилтын 7 “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээл, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлж, эдийн засгийн чадамж, үр өгөөжийг сайжруулах;
- “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.9-д заасан “Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, газар тариалан, хөдөө аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэлд түшиглэсэн орон нутгийн логиستيкийн төвүүдийг байгуулах”;
- “Атар-4” Тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.4. “(Улаанбаатар хотод) Хадгалалт, борлуулалтын нэгдсэн сүлжээ бүхий худалдааны цогцолбор байгуулахыг дэмжих” ба 4.5 “Төмс, хүнсний ногооны механикжсан агуулах, жимс жимсгэнэ, чимэглэлийн ургамлын тарьц суулгац хадгалах зоорь байгуулах”;
- “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.14. “Стандартын шаардлага хангасан үр тарианы элеваторын багтаамжийг 20.0 мянган тонноор, төмс, хүнсний ногоог хадгалах механикжсан агуулах, зоорийн багтаамжийг 50.0 мянган тонноор тус тус бүсчилсэн байдлаар нэмэгдүүлэх”.

Цогцолбор төвийн чиг үүрэг, үйл ажиллагааны схем, бүтэц

Хадгалалт, борлуулалт, түгээлтийн цогцолбор төв нь төмс, хүнсний ногоог үндсэн ханган нийлүүлэгчид болох тариаланчдын бүтээгдэхүүнийг түр хадгалж, нэмүү өртөг шингээн, захиалгат ба бөөний худалдааны хэлбэрээр худалдан авагчдад нийлүүлэх чиг үүрэгтэй. Төвийн үйл ажиллагаа “татан авалт – хадгалалт – боловсруулалт – худалдан авалтын захиалга авах – нийлүүлэх” гэсэн ерөнхий үе шатуудаас бүрдэнэ. Үйл ажиллагааны ерөнхий схемийг 2-р зурагт бүдүүвчлэн үзүүлэв.

Цогцолбор төв хөргөлттэй баталгаат агуулахууд, бөөний худалдааны төв, хүнсний аюулгүй байдлын лаборатори, хүнсний ногоо боловсруулах цех, сав, баглаа боодлын цех гэсэн үндсэн объектууд болон захиргаа, үйлчилгээний бусад объектуудаас бүрдэнэ (3-р зураг). Гол объектуудыг зургийн дор товч танилцуулав.

Бөөний худалдааны төв - Монгол улсад 2021 оны байдлаар нийт 182.6 мянган тонн төмс, 197.2 мянган тонн хүнсний ногооны нийт 379.8 мянган тонн нийлүүлэлт хийгдсэний 50 хувь нь буюу ойролцоогоор 190 мянга нь Улаанбаатар хотод ногддог гэж үзвэл тус хотын дэргэд байрлах бөөний худалдааны төв нь нийслэлийн төмс, хүнсний ногооны хэрэгцээний 40 хувийг, нийт нийлүүлэлтийн 20 хувийг хангах хүчин чадалтай буюу жилд 75 мянган тонн борлуулалт хийх хүчин чадалтай байх шаардлагатай.



Зураг 2: Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн цогцолбор төвийн үйл ажиллагааны ерөнхий схем



Зураг 3: Хүнсний ногооны хадгалалт, борлуулалт, түгээлтийн цогцолбор төвийн объектууд

1-бөөний худалдааны төв, 2- хүнсний чанар, аюулгүй байдлын лаборатори, 3-бүдүүн ногооны агуулах, 4-нарийн ногооны агуулах, 5-бараа материалын агуулах, 6-хүнсний ногоо боловсруулах цех, 7-сав, баглаа боодлын цех, 8-авто засварын газар, 9-шатахуун түгээх станц, 10-автомашин угаалгын газар, 11-автомашину зогсоол, 12-зочид буудал, 13-захиргааны байр, 14- үйлчилгээний төв, 15-ажиллагсдын орон сууц, 16-ажиллагсдын үйлчилгээний байр, 17-хог хаягдал ангилах байгууламж

Хүнсний ногооны агуулахууд – Манай оронд температурын тохируулгатай механикжсан агуулахын нийт хүчин чадал 66.1 мянган тонн байгаа нь нийт хэрэгцээний дөнгөж 18 хувийг хангаж байна. Цогцолбор төв жилд 75 мянган тонны борлуулалт хийнэ гэсэн тооцоонд дүйцүүлбэл үндэс үртэн,



байцаа, сонгино зэрэг өргөн хэрэглээний ногоо хадгалах 10 мянган тонны, нарийн ногоо, жимс жимсгэнэ хадгалах болон дамжин өнгөрүүлэх зориулалтын 10 мянган тонны иж бүрэн автоматжсан 2 агуулах шаардагдана. Хоёр агуулах тус бүртээ сортлогооны шугамтай, бүдүүн ногооны агуулах нь мөн 25 кг болон 50 кг-аар савлах шугамтай байна. Нийт 20 мянган тоннын хүнсний ногооны 2 механикжсан агуулах ашиглалтад оруулснаар Монгол улсын механикжсан агуулахын нийт хүчин чадал даруй 30 хувиар нэмэгдэнэ.

Хүнсний аюулгүй байдлын лаборатори - Цогцолбор төвд байрлах ХАБ-ын лаборатори нь төвөөр дамжин борлогдох бүх хүнсний ногоо, жимс жимсгэний дээжид хөнөөлт организм, пестицид ба бусад химийн бодисын үлдэгдэл, эрүүл ахуйн шинжилгээг MNS болон ISO стандартуудаар гүйцэтгэж, баталгаажуулалт олгоно. Зөвхөн ХАБ-н баталгаажуулалт хийгдсэн хүнсний ногоо, жимс жимсгэнийг цогцолбор төвд худалдана. Лабораторийн барилга дотор түүнчлэн хүнсний аюулгүй байдал, ургамлын эрүүл ахуй, хорио цээр хариуцсан улсын байцаагчдын ажлын өрөө байрлана.

Хүнсний ногоо боловсруулах цех - Монгол улс 2021 онд 1088 тонн хөлдөөсөн ногоо, 153 тонн хатаасан ногоо импортлоход 2 сая ам.доллар зарцуулсан. Дотоодын хүнсний ногоонд нэмүү өртөг шингээж, импорт орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд цогцолборын бүтцэд хүнсний ногоо угааж, хэрчиж, хөлдөөх болон савлах шугамуудтай боловсруулах цехийг байгуулах нь зүйтэй. Импорт хөлдөөсөн ногоо голлож буй тул эхний ээлжинд цехийг 1000 тонн хөлдөөсөн ногоо үйлдвэрлэх хүчин чадалтайгаар байгуулж, цаашид хатаасан ба бусад хэлбэрээр боловсруулсан ногоо үйлдвэрлэх хэтийн төлөвлөгөөтэй ажиллана. Хүнсний ногоо савлах шугам нь супермаркетууд худалдааны төвүүдийн тавьсан шаардлагад нийцүүлэн жилд нийт 30 мянган тонн боловсруулаагүй болон боловсруулсан (угааж, хэрчиж, хөлдөөсөн) хүнсний ногоо, жимс жимсгэнийг дангаар нь болон холимог байдлаар 0.5-5 кг-аар торон ба пластик уутанд савлах хүчин чадалтай байна.

Сав, баглаа боодлын цех – Монгол улсад хамгийн их дутагдаж буй үйлдвэрлэл болох хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын цехийг цогцолбор төвд байгуулж, ажиллуулах нь зүйтэй. Тус цех төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ савлах торон ба тааран шуудай, пластик уут, жижиг хайрцагийг төрөл бүрийн хэмжээгээр тогтмол үйлдвэрлэх ба нэмэлт бүтээгдэхүүнүүдийг захиалгын дагуу нийлүүлнэ. Төвд худалдаалагдах 75 мянган тонн хүнсний ногоо, жимс жимсгэнийг төрөл бүрийн хэмжээгээр савлах нийт сав, боодлоос гадна захиалгаар нэмж үйлдвэрлэнэ гэж тооцвол тус цех нь жилд 50 кг-ын шуудай 1.2 сая ширхэг, 25 кг-ын шуудай 500 мянган ширхэг, 10 кг-ын картон хайрцаг 3 сая ширхэг, 5 кг-ын картон хайрцаг 1.5 ширхэг, 0.5-1 кг-ын пластик уут 5 сая ширхэг, 2-5 кг-ын савлах пластик уут 1 сая ширхэгийг тус тус үйлдвэрлэх хүчин чадалтай байна.

Бусад объектууд – Олон улсын жишигт нийцсэн цогцолбор төв нь түүнчлэн бараа материалын агуулах, автомашины зогсоол, авто засварын төв, шатахуун түгээх станц, авто угаалгын төв, зочид буудал, үйлчилгээний төв, захиргааны байр, хог хаягдал ангилах байгууламж зэрэг объектуудтай байна.

Улаанбаатар хотын дэргэд байгуулах цогцолбор төвд нийт 3.5 га газар шаардагдах ба үүний 1 га-г бөөний худалдааны төвийн барилга, 1 га-г автомашины зогсоол, зам болон бараа ачих, буулгах сул талбай, 1 га талбайг хүнсний ногоо, жимс жимсгэний 2 агуулах, 0.5 га талбайг бусад барилга, байгууламжууд тус тус эзэлнэ.

Талуудын оролцоо, үүрэг, хариуцлага

Дэлхийн улс орнуудад хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын цогцолборуудыг төрийн, хувийн өмчийн болон хамтран хувь эзэмшсэн хэлбэрээр байгуулах олон хувилбарууд нэвтэрснээс а) төр,



хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар төр, хариуцагч компани, ногоочдын хоршоод гэсэн гурван талын хамтарсан хувьцаат компанийн хэлбэрээр, эсвэл б) төрөөс гарааны хөрөнгө оруулалтын зохих хувийг эргэн төлөгдөх нөхцлөөр хариуцаж, хариуцагч компани болон ногоочдын хоршоодын хамтын өмчлөлийн хэлбэрээр байгуулах хувилбарууд Монгол орны нөхцөлд тохиромжтой бөгөөд үндэслэлийг нь товч танилцуулъя.

Төрийн оролцоо, чиг үүрэг: Улаанбаатар хот, бүсийн тулгуур аймгуудад цогцолбор төвүүдийг байгуулахад их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана. Зөвхөн Улаанбаатар хотын дэргэд энэхүү бодлогын зөвлөмжид санал болгосон цогцолборыг байгуулахад 100 тэрбум орчим төгрөгийн санхүүжилт шаардагдана. Нэг талаар хүнсний ногооны салбарт ийм хэмжээний хөрөнгө оруулалтыг дангаараа хариуцах аж ахуйн нэгж, ногоочдын хоршоод ховор, нөгөө талаар эдгээр төвүүд нь цөөн компанийн хувийн бизнес биш, нийт ногоочдыг хамруулсан нийгмийн бизнес (social entrepreneurship) хэлбэртэй байх нь зохистой тул хөрөнгө оруулалтад төр оролцох нь зүйтэй бөгөөд шаардлагатай. Төр хамтран хувь эзэмших хувилбарыг авч үзвэл нийт хөрөнгө оруулалтын 1/3 буюу 33.3 хувийг хариуцагч компани санхүүжүүлж, харин төрийн ба ногоочдын хоршоодод ногдох нийт 2/3 буюу 66.7 хувийг төрөөс гарган, үүний тал хувийг эхний жилүүдэд хоршоодод ногдох ашгаас нөхөн төлүүлж, 33.3 хувийг төрд үлдээвэл цаашид гурван тал тус бүр 33.3 хувь эзэмшиж, тэгш эрхтэй хамтран ажиллах таатай нөхцөл бүрдэнэ. Харин төр хувь эзэмшихгүй байх тохиолдолд хөрөнгө оруулалтын 50 хүртэлх хувийг төр хариуцаж, хариуцагч компаниар нөхөн төлүүлэх нь хамгийн боломжтой хувилбар гэж үзэж байна.

Цогцолбор төвүүдийн үйл ажиллагааг салбарын бодлогод уялдуулах, төвийн борлуулалтыг төрийн худалдан авалтад холбох, төвийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргүүд нь цогцолбор төвд хувь эзэмших, эсвэл үл эзэмшихээс үл хамаарч төрд ногдоно.

Ногоочдын хоршоодын оролцоо, чиг үүрэг: Ногоочдын хоршоод ханган нийлүүлэгч, борлуулагчийн үндсэн чиг үүрэгтэйгээр төвийн үйл ажиллагаанд оролцоно. Ногоочид төлөөллийн байгууллага болох хоршоодоор дамжин төвд хувь эзэмшсэнээр төвийн үйл ажиллагаа амжилттай байх тусам үр шимийг нь өөрсдөө шүүд хүртэх нөхцөл бүрдэх тул төвд нийлүүлэх хүнсний ногооны хэмжээ, чанар, стандарттай холбоотойгоор хүлээсэн үүргээ илүү хариуцлагатай биелүүлэх түлхэц болж өгнө. Түүнчлэн ногоочдын хоршоод томоохон бизнесийн хувь эзэмшигчид болсноор санхүүгийн чадавч нь эрс сайжирч, улмаар газар тариалангийн салбарт хоршооллын хөгжлийг олон улсын жишигт нийцүүлэх бодит боломж бүрдэнэ.

Хариуцагч аж ахуйн нэгжийн оролцоо, чиг үүрэг: Хариуцагч компани нь цогцолбор төвийн ерөнхий удирдлага, өдөр тутмын үйл ажиллагаа, борлуулалт, түгээлт, санхүүг хариуцах тул нилээд удирдлага, санхүүгийн өндөр хүчин чадалтай байх шаардлагатай. Түүнчлэн олон мянган ногоочид, тэдгээрийн төлөөллийн байгууллагатай хамтран ажиллах хариуцлага, үр чадвар шаардагдана. Цогцолбор төвийн удирдлага нэг аж ахуйн нэгжийн хүчин чадлаас давах магадлалтай тул зарим үйл ажиллагааг туслан гүйцэтгэгчдэд хариуцах хувилбарыг хэрэгжүүлэх нь оновчтой байж болно. Жишээлбэл цахим бирж, тээвэрлэлт, хүнсний аюулгүй байдлын лаборатори зэрэг үйл ажиллагааг тухайн салбарын мэргэшсэн байгууллага, ААН-үүдэд хариуцуулах нь илүү үр дүнтэй байж болно.

Бусад оролцогчид, тэдгээрийн чиг үүрэг: Цогцолбор төвийн үйл ажиллагааг олон улсын ISO стандартад нийцүүлэх, тогтвортой байдлыг хангах, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн уялдаа холбоог хангахад ХААИС, ХХААХҮСХТ, УГТХ, ШУТИС зэрэг мэргэжлийн байгууллагуудын оролцоо зайлшгүй шаардагдана. Мөн хамтран ажиллах ногоочдын хоршоодыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, чадавхжуулах ажлуудыг салбарын мэргэжлийн холбоод хариуцан ажиллах нь зүйтэй. Түүнчлэн



стандартчилал, сертификатжуулалтын ажлыг чиглэл тус бүрээр төрөлжсөн хариуцсан байгууллага, ААН-үүдэд хариуцуулах, цаашид ХАА-н бүтээгдэхүүний олон улсын биржийн сүлжээнд холбогдож, бүтээгдэхүүнээ экспортлоход олон улсын зөвлөх компаниудын дэмжлэгийн авах зэрэг олон талын оролцоо бүхий хамтын ажиллагаа шаардагдана.

Ашигласан хэвлэл

Азийн Хөгжлийн Банк (2020). “Монгол улсын хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртгийн сүлжээ” судалгааны тайлан. Цахим хаяг:

<https://www.adb.org/sites/default/files/publication/674011/vegetable-production-value-chains-mongolia-mn.pdf>

Үндэсний Статистикийн Хороо (2016): Хөдөө аж ахуйн салбар 2016. Улаанбаатар: ҮСХ.

Үндэсний Статистикийн Хороо (2022a): Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2021. Улаанбаатар: ҮСХ.

Үндэсний Статистикийн Хороо (2022b): Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтүүд 2021 онд. Улаанбаатар: ҮСХ.

Mongolian Farmers’ Association for Rural Development (2016). Study on Mongolian vegetable sector and value chain situation. Commissioned by: Support to Employment Policy for promoting job creation in Mongolia (SECIM) project.

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогч

Б.Эрдэнэболор, PhD

Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн ахлах зөвлөх

Имэйл: erdenebolor@iaktleipzig.de